

БАРУУН-УРТ СУМЫН 4 ДҮГЭЭР САРЫН МЭДЭЭ

ТӨРИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО:

Архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр:Тайлант сарын байдлаар Тамгын газраас 59 бичиг явж, 61 бичиг ирсэн байна.Үүнд:

Хариутай бичиг-12, хугацаандаа явсан-8, хугацаа болоогүй-4 байна.

Тус Тамгын газраас явсан бичгийг стандартын дагуу зохион бүрдүүлж ажилласан. Мөн ирсэн албан бичгийг удирдлагад цаг тухай бүрт танилцуулан холбогдох мэргэжилтэнд хүлээлгэн өгч, барагдуулалтад хяналт тавьж ажиллалаа.

Тус Тамгын газар нь албан хэргээ хос бичгээр хөтөлж хэвшсэн.

Байгууллагын даргаас гаргасан 33 шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг хянаж, зөрчилгүй шийдвэр гаргаж хэвшсэн.

“Малын А” дансны лавлагаа авах хүсэлт гаргасан 7 иргэнд лавлагаа гарган өгсөн.

Багийн Засаг даргаас 464 иргэнд тодорхойлолт гаргаж үйлчилсэн.

Төрийн үйлчилгээний оператор 940 иргэнд төрийн цахим үйлчилгээний лавлагаа гаргаснаас төлбөртэй үйлчилгээ 112, төлбөргүй 822 байна.Үүнд:

- 1.Нийгмийн датгалын шимтгэл төлөлтийн талаарх мэдээлэл -85
2. Иргэний үнэмлэхний лавлагаа-42
3. Шүүхийн шийдвэр бусдад өр төлбөргүй эсэх лавлагаа-245
4. Үл хөдлөх хөрөнгийн лавлагаа-5
5. Иргэнд олгох тодорхойлолт-247
6. Зээлийн бүрэн мэдээлэл-48
7. Эрүүл мэндийн даатагал-42
8. Үл хөдлөх хөрөнгө жагсаалтаар -32
9. Оршин суугаа хаягийн лавлагаа-5
10. Үл хөдлөх хөрөнгөтэй эсэх-29
11. Төрсний бүртгэлийн лавлагаа-9
12. Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх-7
13. Жолоочийн лавлагаа-7
14. Хүүхдийн мөнгөнд хамрагдсан эсэх -14
15. Гэрэлсний бүртгэлийн лавлагаа-5
16. Өндөр настны тэтгэвэр тогтоололын хуудас -146
17. Жолооны үнэмлэх захилга -3
18. Шүүхийн шийдвэр бусдад өр төлбөргүй эсэх ААН-6
19. Газрын кадастрийн зураг-5
20. Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх-9
21. Авто тээврийн хэрэгсэл эзэмших эрхийн лавлагаа-1
22. Гэрлээгүй бүртгэлийн лавлагаа-1
23. Мал тоологын лавлагаа-1
24. Нийгмийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардалатай эсэх -2
25. Эрүүл мэндийн цаг авах-1
26. Тэтгэвэр авах эрх үүсээгүй лаюлагаа -1
27. Хуулийн этгээд нэр баталгаажуулах -2
28. Хөдөлмөрийн чадвараа алдсан тэтгэвэр тогтоололтын хуудас-2
29. Хуулийн этгээд дэлгэрэнгүй лавлагаа-1
30. Хуулийн этгээд үүсгэн байгуулагч -1
31. Гэрэлсний бүртгэлийн лавлагаа /англи/-1
32. Үндэсний гадаад паспортны бүртгэлийн хуудас-1

33. Жирэмсний тэтгэмж илгээх хуудас-3
34. Кадасртийн зураг-2
35.Цагдаагийн төв архивын лавлагаа-1
36. Шинжилгээний хариу авах-2 Нийт 36 төрлийн 940 лавлагааг 940 иргэнд гаргаж өгсөн.

Тамгын газраас хийж хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээг олон нийтэд мэдээлэх зорилгоор орон нутгийн BBS тв, Сүхбаатарын өнгө сонин, Sb ingo сайт хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран 10 удаа мэдээлэл нийтэлсэн.

Багийн Засаг дарга нар айл өрхөөр явж иргэдийн санал хүсэлтийг сонсож ажилласан.

Тайлант сарын байдлаар байгууллагын цахим хуудсаар хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар мэдээ, мэдээллийг түгээж байгаа бөгөөд мэдээллийг харсан 40000 иргэн үүнээс идэвхитэй мэдээлэл харсан 10231 иргэн хандсан байна.

Өдөрт давхартсан тоогоор 2000 гаруй иргэн байгууллагын цахим хуудсаар зочилж мэдээлэл авч байна.Тайлант сард мэдээлэл оруулсан байдлыг ангилвал:

Фото мэдээлэл-38, видео мэдээлэл-4, текст мэдээлэл-6, шэйр мэдээлэл-3 тус тус нийтэлсэн байна.

Багуудын ИНХурал 2023 оны 04 дүгээр сард зохион байгуулагдлаа.Хурлын үеэр:

Багуудын ИНХ-д аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгчид оролцож ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлын тайланг танилцуулж, багийн Засаг дарга ажлаа тайлагнан, Сүхбаатар тохижилт үйлчилгээ, Дөрвөлж, Уртын гэгээ ОНӨААТҮГ-ууд, багийн хэсгийн байцаагч, “Энэрэлт ачтан” өрхийн эрүүл мэндийн төв зэрэг байгууллагууд оролцож, мэдээлэл өгч хамтарч ажиллалаа. Мөн 2024 онд ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажилд саналаа авч,иргэдийн санал хүсэлийг сонсож ажиллалаа.



Хууль эрх зүйн чиглэлээр:Төрсний бүртгэл-225, эцэг эх тогтоосны бүртгэл-6, нэр өөрчилсний бүртгэл-5, Иргэний үнэмлэхний хугацаа дуусч авсан-225, шинээр олгосон иргэний үнэмлэх-138, Аймаг, хотоос шилжин ирсэн-49, хот доторх шилжилт хөдөлгөөн-168, сум дүүрэгт шилжин ирсэн-11, баг хооронд шилжсэн-170, гэрлэлт цуцлалт-11, Үрчлэлт-3, овог нэр өөрчилсөн-5, нас баралт-47 тус тус бүртгэн үйлчилсэн байна.

МУ-ын Засгийн газраас санаачлан боловсруулсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн талаарх олон нийтийн хэлэлцүүлэг, санал асуулга зохион байгуулагдлаа.Уг хэлэлцүүлэгт Тамгын газрын болон харъяа төсөвт байгууллагын албан хаагчид хамрагдаж саналаа өгсөн.



Нийгмийн даатгалын багц хуулинд өөрчлөлт оруулах тухай хуулийн хэлэлцүүлэгт сумын иргэдийг хамруулж, санал, бодлыг нь тусгуулан хамтран ажиллалаа.

“Зөв хэвшил-Зөв амьдрал” хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын хүрээнд өсвөр насны хүүхдүүдэд санхүүгийн боловсрол, хувийн санхүүгээ удирдах буюу хэрэглээ хүслээ ялган таних, хуримтлалын талаар зөв ойлголттой болох, гар утасны хэрэглээний аюул, боломжийн талаар мэдлэг ойлголт олгох сураглтыг 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр ерөнхий боловсролын 2, 4 дүгээр сургуулийн 6 дугаар ангийн 16 бүлгийн 314 сурагчдад зохион байгууллаа.

Санхүү, төрийн сан, хөрөнгө оруулалтын чиглэлээр: 4-р сарын байдлаар Татварын болон татварын бус орлого нь 2,119,507.4 мянган төгрөг төвлөрч, орлогын төлөвлөгөө 89.6 хувьтай байна.

14 байгууллага, 19 иргэний 4,030.0 мянган төгрөгийн УТХ, ХАОАТ, торгуулийн буцаалтын өргөдлийн бүрэн шийдвэрлэсэн.

Төрийн сангийн төлбөр тооцооны цахим системээр 5,005.9 сая төгрөгийн 1628 ш гүйлгээг баталгаажуулж ажиллалаа.

Харъяа төсөвт байгууллагуудын 723 төлбөрийн хүсэлт ирснээс 630 гүйлгээг баталгаажуулсан байна. Залруулсан болон алдаатай 93 гүйлгээ байна. Нийт 2,054,974,179.77 төгрөгийн гүйлгээ баталгаажуулсан. Хавсралт материал дутуу шаардлага хангаагүй, хамааралгүй баримт хавсарсан болон системийн алдаанаас шалгаалан буцаагдсан гүйлгээнүүдийг тухай бүрт буцаан алдааг засварлаж ажиллалаа.

2023 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 5 дугаар багийн 10-н айлын дээвэр засварын ажлыг 2022 онд тендер зарлаж тендэрт Молцог элс ХХК 31,453.4 мянган төгрөгийн үнийн саналаар шалгарч ажил гүйцэтгэх гэрээ байгуулж гэрээний дагуу дээвэр засварын ажлыг Засаг даргын А/99 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн. Энэхүү төсөл арга хэмжээ хэрэгжсэнээр 30 иргэний амьдрах тав тухтай орчин нөхцлийг бүрдүүлсэн байна.

2023 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Ухаалаг тоног төхөөрөмж нийлүүлж, суурилуулах ажлын тендер цахимаар зарлагдаж тендэрт "Баялаг говь" ХХК 53,999.0 мянган төгрөгийн үнийн саналаар шалгарч ажил гүйцэтгэх гэрээ байгуулж гэрээний дагуу төхөөрөмжийг 2,4,5,9 дүгээр багуудын усан сангуудад суурилуулж сумын Засаг даргын А/105 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт хүлээлгэн өглөө. Энэхүү төхөөрөмж нь орчин үеийн дэвшилтэт технологид суурилсан,

Ухаалаг төхөөрөмж бөгөөд ус түгээх цэгт суурилагдсанаар иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, цаг хугацааг хэмнэсэн, иргэд өөрсдийн усны хэрэглээгээ хянах боломжтой зэрэг олон давуу талтай болж ямарч картаар аль ч усан сангаас усаа авах

нөхцөл бүрдсэн байна. Нэмэлтээр 3 дугаар багийн нутаг дэвсгэрт баригдаж буй усан санд мөн суурилуулах юм.



2022 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан болон 2023 оны батлагдсан төсөв багийн ИНХ-ын дарга болон сумын Засаг дарга, ИТХ-ын дарга, орлогч дарга нарт бэлтгэсэн слайд танилцуулсан. Багийн ИНХурал дээр 2022 оны ОНХС тайлан, 2023 оны батлагдсан төсөв танилцуулж ажилласан.

Агуулах авто граж нийлүүлэх, зуны сувилал байгуулахад шаардлагатай зөөврийн сууц худалдан авах, нэгдсэн камержуулалт тоног төхөөрөмж худалдан авах, 1 дүгээр багийн тоглоомын талбай, 3 дугаар багийн тоглоомын талбай байгуулах ажлын нийт 5 үнэлгээний хороо байгуулж ажиллалаа.


Ногоон байгууламжийн усалгаа арчилгаа, саруул хотхоны гадна талбайн тохижилт, Жаргалан хотхоны гадна талбайн тохижилт, ухаалаг худаг тоног төхөөрөмж суурилуулах ажил буюу нийт 17 удаа үнэлгээний хороо хуралдсан байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын хүрээнд 36,4 сая төгрөг санхүүжилттэй 7 төсөл арга хэмжээний баримтын анхан шатны бүрдлийг хянан бүрдүүлэн ажиллалаа.

Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр:"Эрүүл аюулгүй ажил-бидний суурь эрх" хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй-2023 сарын аяны хүрээнд аймгийн Засаг даргын Т амгын газар, Цагдаагийн газар, Хүнс хөдөө аж ахуйн газар, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Нийгмийн даатгалын газар, Татварын хэлтэстэй хамтарч Баруун-Урт сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, байгууллагын төлөөлөлд холбогдох хууль тогтоомжийг сурталчлан таниулах уулзалтыг зохион байгууллаа. Тус уулзалтад нийт 40 аж ахуй нэгжийн төлөөлөл оролцлоо.

Баруун-урт сумын 9 дүгээр багийн залуучуудын "Хайлаастын залуус" чуулга уулзалт 4 дүгээр сарын 14-ний өдөр 9 дүгээр багийн ИТХ-ын төлөөлөгч, багийн ажлын алба хамтран зохион байгууллаа. Тус чуулга, уулзалтад:

- Багт хийгдэж буй хөрөнгө оруулалтын ажлууд
- Багийн ажлын албаны тайлан
- Залуучуудын оролцоо сургалт
- 2024 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын санал асуулга авах
- асуулт/хариулт, санал/хүсэлт гэсэн хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдаж багийн 87 залуус оролцож төрийн үйл ажиллагааны талаар мэдээ мэдээлэл авч, багт тулгамдаж буй асуудлыг харилцан ярилцсан эерэг үр дүнтэй уулзалт болж өндөрлөлөө.



2023 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулсан бүх нийтийн өглөөний гүйлтийг, Мал эмнэлгийн газар, Өсөх дэлгэр ундрах, 2-р бүрэн дунд сургуультай хамтран зохион байгууллаа. Арга хэмжээнд нийт 400 гаруй хүн оролцсон.



Эрүүл хүүхэд өдөрлөг

Баруун-Урт сумын 5 дугаар багийн ажлын алба, Аймаг, Сумын ИТХ-ын төлөөлөгчид зохион байгуулж буй Хүүхдийн хөгжил, хамгааллыг дэмжих жилтэй холбогдуулан "Эрүүл хүүхэд" өдөрлөг 2023 оны 03 дугаар сарын 27, 28-ны өдрүүдэд зохион байгуулж хүүхдийн эрүүл мэндийн үзлэг, шүдний урьдчилан сэргийлэх үзлэг, зөвлөгөө, эрдэсжүүлэх болон цоорлын түрхлэг зэрэг үйлчилгээг 232 хүүхдийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг хийгдлээ.

Хүнс хөдөө аж ахуйн чиглэлээр: Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2022 оны А/518 дугаар тушаал, Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Засаг даргын 2023 оны А/48 дугаар захирамжийн дагуу "Мал амьтны сэг зэм, орчны бохирдол хог хаягдлыг цэвэрлэх, ариутгал халдваргүйжүүлэлт хийх ажлыг Сүхбаатар тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГазартай хамтран хийлээ. Тус ажилд Сүхбаатар тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГазрын 1 ковш, 1 кама, 2 жолооч, Тамгын газрын 1 суудлын автомашин, 1 ариутгалын ДУК машин, 2 мэргэжилтэн, 1 жолооч, 2 туслах ажилтан ажиллан 3,205,900 зарцуулж, 25000 м2 бэлчээрийн талбайг цэвэрлэн 96 тн хогийг цэвэрлэж хогийн нэгдсэн цэгт асгасан. Мөн 1500 гаруй үхсэн малын сэг зэмийг түүж булж устган таван эрдэнэ малтай хорооллын 1,5 га талбайн хогийн нэгдсэн цэгт түрэлт хийж овоолго үүсгэн хогийн цэгийг цэгцлэн, 25000 м2 талбайд ариутгал халдваргүйтгэл тус тус хийгдсэн.

Баруун-Урт сумын хэмжээнд 3000 га талбайд оготно устгалын ажлыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Аймгийн нөөц сангаас тус суманд 60 шуудай буюу 2,1 тн оготно устгалын хор буюу хордуулсан будааг хүлээлгэн өгөөд байна. Тус ажлыг 5-р сарын 5-ны өдрөөс зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Газрын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөд" Бэлчээрийн асуудлаар хэлэлцүүлэг Сүхбаатар суманд 4-р сард зохион байгуулагдсан. Тус хэлэлцүүлэгт төвийн сумын 1076 малчин өрхийн эрх ашгийг хамгаалах талаар хуулийн төсөлд тусгах, бэлчээрийн бүлэгт онцгой анхаарах зэрэг асуудлаар санал хүсэлтийг тавьсан. Тус хэлэлцүүлэгт тус сумын Засаг дарга, 8-р багийн Засаг дарга, 30 гаруй малчны төлөөлөл оролцож санал хүсэлтээ илэрхийлж ажиллалаа.

Малын сэг зэм устгал, бэлчээр цэвэрлэгээ ариутгалын тайлан Байгаль орчин аялал жуулчлалын



сайдын 2022 оны А/518 дугаар тушаал, Сүхбаатар аймгийн Баруун урт сумын засаг даргын 2023 оны 02сарын 27ны өдрийн А/48 дугаар захирамжаар 03 дугаар сарын 20-ны өдрөөс 04-р сарын 01-ны хооронд "Мал амьтны сэг зэм, орчны бохирдол хог хаягдлыг цэвэрлэх, ариутгал халдваргүйжүүлэлт хийх ажил хийгдсэн. Тус ажлын хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулж үр дүнд хүрсэн. - 1,2,3-р гуу, хуучин агро парк, клонк, цэвэрлэх байгууламж, хогийн цэгийн урд хэсэг, Уртын голын эх, Таван эрдэнэ малтай хороолол, Өлгий зэрэг нийт 10 хэсэг газарт үхсэн малын сэг зэм, бэлчээрт үүссэн эзэнгүй хог хаягдлыг цэвэрлэж ариутгал халдваргүйтгэлийн ажлыг хийсэн. - 25000 м2 талбайд ариутгал халдваргүйтгэл хийгдсэн.

Сумын ИТХ-н 16 дугаар хуралдаанаар Малчдын залуу халаа” хөтөлбөрийг хэлэлцүүлэн батлуулж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган Засаг даргаар тус тус батлуулан ажиллаж байна.

ХАА-н цогцолборт төмс хүнсний ногоо, ногоон тэжээл тариалалт хийх талбайн хагалгаа, үрэлгээ хийх зорилгоор Нараншарга агро ХХК-тай 12,0 сая.төгрөгийн шууд ажил гүйцэтгэх гэрээ байгуулан хагалгааны ажлыг эхлүүлээд байна.

ХАА-н цогцолборын талбайг тэлж 25 га талбайд үйл ажиллагаа явуулах ба ногоон тэжээл тариалах талбай 2022 онд 7,5 га талбай байсан бол 2023 онд нэмэлтээр 12 га атар газрыг нэмж хагалан нийт 19 га талбайд тариалахаар газар хагалгаа үрсэлгээг “Наран шарга агро” ХХК-тай гэрээ байгуулан хагалгааны ажлыг эхлүүлж байна.

Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж 4-р сарын 20-ны өдөр батлуулсан. Тодотголоор мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнийг тодотгосон. Ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийн аврах бүлгийн 30 албан хаагчийг байнгын бэлэн байдлыг хангаж 2 удаа шалгасан. Мөн байгаль цаг уурын гамшигт үзэгдлийн үед 1-р багийн нутаг дэвсгэрт Хангамжийн 8 айлын орон сууцны дээвэр хуурч 1 машины дээрээс унасан байсныг мэргэжлийн ангийн аврах бүлгийн 15 албан хаагч аюулгүй болгож ажилласан.

Гамшгийн үеийн нөөцийг 40,0 сая.төгрөг ОНХСангийн хөрөнгөнд тусгуулж баталсан ба 4-р сард цэцэг өвчний вакцинжуулалт -318,8 мянган төгрөг, 1-р багийн хангамжийн 8-н айлын орон сууцны дээвэр засварт 3,000,0 мянган төгрөгийг тус тус зарцуулаад байна.

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын 4-р багийн нутаг хүүхдийн худаг гэдэг газар нутаглаж буй Баруун-Урт сумын 8-р багийн малчин М.Ганбатын хотноос малын гоц халдварт цэцэг өвчний шинж тэмдэг бүхий дуудлага ирсэний дагуу тус сумын малын эмч дуудлагаар очиж үзлэг хийн, дээж материалыг УМЭТЛабораторит хүргүүлсэн бөгөөд уг дүгнэлтийг үндэслэн 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/116 тоот захирамжаар хязгаарлалтын дэглэм тогтоож, хөдөлгөөнт болон суурин пост, дархлаажуулалтын ажлын хэсэг гарган өвчлөл бүхий газраар машин тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг хориглон, хяналт тавин ажиллаж байна.

Бог малын мялзан, хонины цэцэг өвчний тандалтад Баруун-Урт сумын малчин, мал бүхий 3 өрхөөс 12 бод 36 богоос дээж авч, аймгийн мал эмнэлгийн газарт хүргүүлэн ажилласан.

“Дэээрэт энэрэл” Олон Улсын байгууллагатай хамтран Баруун-Урт сумын 9 багийн малын болон төлийн хорогдол их, өвөлжилт хүндэрсэн, малчин айл өрхүүдээр 2023 оны 04 дүгээр сарын 06-наас 12-ны өдрүүдэд 80 малчин өрхөд хүнсний тусламж дэмжлэгийг малчны хотонд хүргэж өгч ажилласан. Мөн Асгат, Сүхбаатар, Мөнххаан, Уулбаян, Халзан сумын нутаг дэвсгэрт амьдарч байгаа өвөлжилт хүндэрсэн 8 дугаар багийн 54 өрх, төвийн 8 багийн өвөлжилт хүндэрсэн 26 айл өрх явж хүнсний тусламж, дэмжлэг үзүүлээ.

Боловсрол, хүүхэд, гэр бүлийн чиглэлээр: Аймгийн ИТХ-ын 02 дугаар тогтоолоор 2023 оныг " Хүүхдийн хөгжил хамгаалал"-ыг дэмжих жил болгон зарласантай холбогдуулан Хүүхдийн эрхийн тухай, Хүүхдийн хөгжил, оролцоо зэрэг асуудлаар тус сургалтыг зохион байгуулсан. Сургалтад Хүүхдийн төлөө үйл ажиллагаа явуулдаг төрийн болон ТББ, аж ахуй нэгжүүд, багийн Засаг дарга, бодлого хариуцсан мэргэжилтэн оролцсон. Сургалтыг Монгол Улсын гавьяат багш, доктор (Ph.D) дэд профессор Х.Баавгай хамтран явуулсан.

Сумын орон тооны бус хэлний бодлогын зөвлөлийн 2023 оны төлөвлөгөө болон аймгийн хэлний бодлогын зөвлөлөөс гаргасан удирдамж чиглэлийн дагуу дараах ажлуудыг хийлээ. Үүнд:

Сумын харъяаны 21 байгууллагын албан хаагчдаас монгол бичгийн төвшин тогтоох шалгалтыг 4 дүгээр сарын 17-20-ны өдрүүдэд зохион байгуулж, нийт 829 албан хаагчаас 691 албан хаагч буюу 83.3% хамрагдсан.

Монгол хэл бичгийн хэрэгжилтийг 19 шалгуур үзүүлэлтийн дагуу байгууллагыг үзэж, цаашид хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний талаар зөвлөмж өгч ажилласан.

Аймгийн ГБХЗХГазартай хамтран эрсдэлт бүлгийн хүүхдүүдийн гэрээр айлчилж, нөхцөл байдлын, эрсдлийн үнэлгээ хийн, хүүхдүүдэд багц гардуулсан.

Хот тохижит, дэд бүтэц, газар зохион байгуулалтын чиглэлээр: Шинээр хийгдэх 7 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах худалдааны гудамжны тохижилтын ажлын зураг төсөв, 1 дүгээр багийн тоглоомын талбайн засвар шинэчлэлийн ажил, 3 дугаар багийн тоглоомын талбайн засвар шинэчлэлийн ажил, 9 дүгээр багийн нутаг дэвсгэр байрлах хяналтын камерын систем холбох ажлын зураг төсвийн ажлыг Батсүндрэл ХХКомпанитай хамтран гэрээ байгуулан хийж гүйцэтгэж байна.

Монгол Улсын ерөнхийлөгчийн зарлигаар 5 дугаар сарын эхний 7 хоногийг мод тарих өдөр болгон зарласантай холбогдуулан орон нутаг хөгжлийн сангийн хөрөнгөөр 30 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 13000 ширхэг модны усалгаа арчилгааны тендерийг зарлаад байна.

5 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах хуучнаар 10 айлын нийтийн орон сууцны дээвэр засварын ажлын тендерт Молцог Элс ХХКомпани шалгарч тус ажлыг хийж гүйцэтгэн комиссоор хүлээн аваад байна.

7 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах жаргалант хотхоны 8 айлын голын талбайн тохижилтын ажил, 2 дугаар багийн нутаг дэвсгэр саруул хотхоны гадна тохижилтын тус бүр 60.0 сая төгрөгийн төсөвтэй тендерүүдийг зарлаад байна.

7 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах нийтийн эзэмшлийн орон сууц Одкон хотхоны 2,3 байр, 276 байрны дээвэр засварын 180.0 сая төгрөгийн төсөвтэй дээвэр засварын ажилд Нар Сар Газар ХХКомпани тендерт шалгарч гэрээний дагуу тус ажлуудыг эхлүүлээд байна.

8 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах ХАА-н паркийн 25 га газрын гадна талын хамгаалалтын торон хашаа татах ажлын трасс болон эргэлтийн цэгүүдийн тавих хашаа татах ажлыг хийж гүйцэтгэсэн.

8 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах Хайлааст үүдэнд байрлах үйлдвэрийн бүсийн 200га газарт хэсэгчилсэн төлөвлөлт хийх ажлын тендерт инженер геодези ХХКомпани шалгарч тус ажлыг газар дээр нь шалгах зураг төсвийн боловсруулалт хээрийн судалгааны ажлыг өнгөрсөн оны 11 сард хийж гүйцэтгэн зураг төсвийг сум болон аймгийн удирдлагуудад урьдчилсан байдлаар танилцуулж ажилласан.

1 дүгээр багийн нутаг дэвсгэрт байрлах Амгалан хороололд дахин төлөвлөлт хийх ажлыг Land Over ХХК хийж тендерт шалгарч хийж гүйцэтгэж байгаа ба тус ажлын хэсгийн бүрэлдэхүүн 3 удаа хуралдаж тус ажлыг гүйцэтгэж байна. Эхний ээлжинд иргэдээс санал авах зах зээлийн судалгааг боловсруулах ажлыг хийж гүйцэтгэж байна.


Газрын тухай хууль тогтоомжийн хүрээнд иргэнд газар эзэмшүүлэх сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор нийт 4 иргэнд газар эзэмших эрх шилжүүлэх захирамжийг сумын засаг даргын захирамжаар гарган газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт хүргүүлсэн.

3.4.5.9 дүгээр багийн нутаг байрлах зөөврийн болон шугамын усан санд ухаалаг систем тоног төхөөрөмж суурилуулах ажлын тендерт Баялаг говь ХХКомпани шалгарч гэрээний дагуу тоног төхөөрөмж угсрах ажлыг хийж гүйцэтгэн 5 худагт тоног төхөөрөмж суурилуулан нэмэлт нэг худгийн тоног төхөөрөмжийг зөөвөрлөх шинэчлэх ажлыг хийж гүйцэтгэсэн.

Баруун-Урт сумын нутаг дэвсгэрт “ХОГГҮЙ БАРУУН-УРТ” хаврын их цэвэрлэгээг 03 дугаар сарын 24-нөөс 04 дүгээр сарын 05-ны өдрүүдэд зохион байгуулж, нийт 78 удаагийн ачилтаар 124.4 тонн хог хаягдлыг хогийн цэгрүү зөөвөрлөж устгасан.



Авт замын гэрэлтүүлгийн ажлын хүрээнд:Төв авто замын гэрэлтүүлгийн гэмтэл, 6 ш гоёлын гэрэлтүүлгийг засварлаж асаалаа.



3-р багийн нуурын баруун авто замын гэрэлтүүлгийн гэмтлийн засварын ажил хийлээ.

3-р тойргийн гэрэлтүүлгийн газрын шугамын тасарсан утасыг засварлалаа.

Авто замын гэрэлтүүлэг болон цамхагт гэрэлтүүлгийн асалтыг 19.30, унтрах цагийг 24.00 тохируулсан.



Гэрэлтүүлгийн шийтний засварын ажил хийгдэж байна.


Цайртын авто зам дагуух гэрэлтүүлгийн гэмтлийг засварлах ажил хийгдэж байна.



Орон сууцны гэрэлтүүлгийн засварын ажлын хүрээнд: Орцны гэрэлтүүлгийн гэмтлийг засварлан, сольж, асаах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: Жаргалант хотхоны 27А байр 2ш, Саруул хотхонд 2ш, Цагдаагийн байранд 2ш гэрэл, Одкон хотхон 1-р байр 1ш, Залуус хотхоны 3-р байрны 6 давхарт- 2ш гэрлийг тус тус засч сэлбэн нийт 7 байрны 6 орцонд мэдрэгчтэй гэрэл 8ш, гэрлийн цагаан потрон 2ш сольж, гэрэлтүүлгийн асалтыг нэмэгдүүлж ажиллалаа.




Салхи шуурганы улмаас хаалга цонх онгойж, шороо шуурах эрсдэлээс урьдчилан сэргийлж, байрнуудын цонхыг хаах, битүүмжлэх ажлыг хийж гүйцэтгэлээ.



Орон сууцны хаалганы засварын ажлын хүрээнд: Орон сууцнуудын орцны хаалга үүд засварлах ажлыг гүйцэтгэж, засварын ажилд нийт 27А, 36А, 48 айл, Залуус 3-р байр, Ногоон хотхон, Саруул хотхон, Цайрт хотхон, Энхжин хотхон, Мандал хотхоны нийт 25 хаалга засварлалаа.



Самбарын засварын ажлын хүрээнд: Сурталчилгааны самбаруудын салхинд урагдсан ананасыг буулгаж, байгууллага аж ахуй нэгжийн самбар байршуулах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: Байгаль орчин аялал жуулчлалын газар, МАЗХ, НЭТ капитал, Бэрс Финанс, МАН зэрэг 5 байгууллагуудын сурталчилгааны самбаруудыг өлгөж, байршуулсан байна.



Нийтийн цэвэрлэгээний ажлын хүрээнд: Төвийн Жаргалан хотхоны тоглоомын талбай, 36А байрны орчин тойрон, 27в байрны урд талын гражийн хажуу тал орчин тойрон, Авидын ногоон байр, Тэмүүлэл-9 айл, 15 айл, аниргүй 8 айл, Цэлмэг хотхон, 60

айл, Дөрвөлж-12 айл, Бааз-8 айл, Цагаан-24, Ягаан-24 айл зэрэг 14 орон сууцны гадна талбайн хог хаягдлыг цэвэрлэж, 4 машин хог ачиж хогийн цэгт асгалаа.



Тэмүүлэл 9 ,15 айл, Авидын ногоон байр



Цэлмэг

ХОТХОН

Дөрвөлж-

12 айл



Орон сууц хотхоны гадна талбайн цэвэрлэгээг 7 хоног бүрийн 3 дахь өдөрт ээлж дараатай цэвэрлэн, тухайн байрнуудын гадна орчныг цэвэр байлгаж, иргэд, оршин суугчдын ая тухтай цэвэр орчныг бүрдүүлж ажиллалаа.

Жаргалан хотхоны 276 байрны подвалын бохир, Цайрт хотхоны 3-р байрны бохирын усыг дахин давтан цэвэрлэж зөөвөрлөх асгах ажлыг хийж, өмхий үнэрийг арилган, ариутгах ажил хийгдлээ.



Орцны дээврийн гарцыг битүүмжлэн засварлах ажлыг хийж гүйцэтгэлээ.



Цэцэрлэгжүүлэлт, ойн ангийн чиглэлээр: Баруун-Урт сумын 5 дугаар тойргийн зам дагуух модны хашааг эвдэж, зам гарган иргэд чөлөөтэй зорчиж байсан хэсгийг Сүхбаатар Тохижилт Үйлчилгээний газар, Баруун-Урт цэцэрлэгжүүлэлт ойн ангитай хамтран замыг шороогоор хааж эвдэрсэн хашааг сэргээн зассан.



Ц.Жигжиджавын цэцэрлэгжүүлэлт хүрээлэнгийн баруун урд байрлах өндөр хүчдэлийн шонгийн ойролцоо ургасан эрсдэл үүсгэж болзошгүй 15 модонд таналт, тайралт хэлбэржүүлэлт хийлээ.



Дэлгэр-Ундрах дэлгүүрийн зүүн уулзвараас Асгат сумруу явах зам дагуух 278 модонд хэлбэржүүлэлт хийж, таналт хийсэн хэсгийг хатахаас сэргийлж будсан.



Тэс Петровисоос боловсрол хорооллын зүүн урд хэсэгт байрлах 252 модонд хэлбэржүүлэлт хийж, модыг хатахаас сэргийлж будгаар будсан.



Одкон хотхоны зүүн талд байрлах хайлаас моднуудад



хэлбэржүүлэлт хийж, өнгө үзэмжийг сэргээн сайжруулсан.

Ц.Жигжиджавын цэцэрлэгт
хүрээлэнгийн баруун болон зүүн
талын зам дагуух модод

болон нийтийн эзэмшлийн зам
дагуух 103 ширхэг улиас моднуудыг
өвчин, хортон шавьжнаас хамгаалах
зорилгоор байгалийн шохойгоор шохойдож, өнгө үзэмжийг нэмэгдүүлж ажиллалаа.



МЭДЭЭ НЭГТГЭСЭН:

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН А.ӨЛЗИЙЖАРГАЛ